ОРХОН АЙМГИЙН 2010 ОНЫ ОНЦЛОХ 10 АЖИЛ

Орхон аймаг 2010 оныг “Цэвэр орчин бүрдүүлэх” жил болгон зарлаж энэ зорилтын хүрээнд аймаг орон нутгийн хөгжил дэвшилд зориулан их бүтээн байгуулалтыг өрнүүлсэн жил болгон ажилласан байна. Өнгөрсөн жилийн онцлох 10 ажлыг нэрлэж байна. Үүнд:

1. Жилийн ажлын хүрээнд тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэсэн бөгөөд нийт дүнгээрээ 45272 мод, 37262 бут сөөг, 7455м^2 зүлэг энэ онд тарьж ургуулж Монгол улсын хэмжээнд “Эрүүл хот”- оор шалгарч, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлаар улсад тэргүүн байр эзэлсэн байна.

2. Баян-Өндөр сумын Дэнж багт 40 ортой эмнэлгийн барилгыг

ашиглалтанд оруулж, тус эмнэлэг Дэнж, Эрдэнэ, Согоот багийн иргэд болон ахмадуудад нарийн мэргэжлийн тусламжүйлчилгээ г үзүүлж байна. 2010 онд 204, он гарсаар 69 нийт 273 иргэнийг хэвтэн эмчлүүлсэн бөгөөд үүний 171 нь ахмад настан байна.

3. Вируслогийн лабораторийг орон нутагт анх удаа байгуулж томуугийн А, В хүрээний вирус илрүүлэх шинжилгээнээс гадна элэгний В,С вирус, бүх төрлийн халдварт өвчнийг молекул биологийн түвшинд онош илж эхлээд байна. Ашиглалтанд орсноос хойш нийт 258 сорьц шинжилсэн байна.



4. Дэнж, Эрдэнэ багт 3.5 км хатуу хучилттай авто зам барих ажлыг “Очир төв” ХХК, Наран, Шанд, Их залуу багт барих 7.4 км авто замын 3.2 км авто замыг Орхон АЗЗА” ХХК, Баянцагаан багт 0.6км, Эрээний гудамжны 1.7 км авто замын шинэчлэлтийн ажлыг “Сэцэд” ХХК тус тус хийж гүйцэтгэсэн байна.

Улсын төсвийн 500 сая төгрөгийн хөрөнгөөр гэр хорооло шинээр цахилгааны 160 кВа-ын 7 дэд өртөө, 6/0.4/0.22 кв-ын 22.2 км урт агаарын шугам, 4, 11-р хорооло 2х1.06 км урт кабель шугамын ажлыг хийж гүйцэтгэв. Мөн орон нутгийн төсвийн хөрөнгөөр Эрдэнэ багийн ногооны талбайн хойд талд цахилгааны 63 кв-ын дэд өртөө, 6/0.4/0.22 кв-ын 3.3 км

урт агаарын шугам, Их залуу багийн баруун энгэрт цахилгааны 63 кВа-ын дэд өртөө 6/0.4/0.22 кв-ын агаарын шугам, Их залуу, Шанд багт 160 кВа-ын 2ш дэд өртөө, 6/0.4/0.22 кв-ын агаарын шугамыг тус тус барьж ашиглалтанд оруулсан байна.

5.

6. Төв цэнгэлдэх хүрээлэнг олон улсын жишигт нийцсэн уралдаан тэмцээн явуулах стандарт шаардлага хангасан 6000 хүний суудалтай барилгын графикт ажил 70.0 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд 2011 онд Эрдэнэт хот байгуулагдсаны 35 жилийн ойн өмнө ашиглалтанд оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

7. Аймгийн мал эмнэлгийн лабораторийг бэхжүүлэх арга хэмжээний хүрээнд Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй шувууны томуу, хүний цар тахалтай тэмцэх чадавхийг сайжруулах өртлөөс 70.0 гаруй мянган долларын, Европын холбооны санхүүжилтээр хэрэгжиж буй малын эрүүл мэнд, мал аж ахуйн зах зээл төслөөс 20 гаруй нэр төрлийн 100.0 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэн, орон нутгийн төсвөөс 31,8 сая төгрөгийн хөрөнгөөр байрыг засварлаж тохижуулан итгэмжлэлд хамруулллаа.

8. 2010 оныг Засгийн газраас “Бизнесийн орчны шинэтгэлийн жил” болгон зарласан бөгөөд энэ ажлын хүрээнд АЗДТГ-аас Бизнес ширээ үйлчилгээг 2010 оны 5-р сараас эхлэн НЦҮ-ний танхимд нээн ажиллуулж байна. Бизнес ширээ үйлчилгээгээр 7 төрлийн үйлчилгээг үзүүлж бизнес эрхлэгчид, иргэдийг шаардлагатай мэдээллээр хангаж ажиллаж байна.
Мөн 2010 онд аймгийн хэмжээнд Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлсэн санхүүгийн дэмжлэгийн үр дүнд 9 үйлдвэр шинээр байгуулагдаж, 16 үйлдвэр үйл ажиллагаагаа өргөжүүлэн эдгээр үйлдвэрүүдэд 143 ажлын байр шинээр бий боллоо.

9. МСҮТ-д уул уурхайн ашиглалт, уурхайн хүнд машин механизмын анги нээж оюутны тоо 40-өөр нэмэгдэв. “Хангайн бүсийн түшиц сургууль” болох эдийн засгийн болон санхүүгийн нөөцийн судалгаа, тооцоо хийж, төсөл боловсруулсан бөгөөд шинээр хөдөө аж ахуйн чиглэлийн сургалттай МСҮТ байгуулагдан ажиллаж байна

10. 2010 оны 12-р сарын 03-нд Аймгийн хэмжээнд албан ёс ны хөдөлмөр эрхлээгүй байгаа хөдөлмөрийн насны ажилгүй иргэдийг оролцуулсан “Иргэний санаачлага-Төрийн дэмжлэг” сэдэвт зөвлөгөөнийг зохион байгуулж зөвлөгөөнөөс гарсан саналуудыг нэгтгэн зөвлөмж гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан бөгөөд 2011 оныг аймгийн Засаг даргын санаачлагаар “Өрхийн амьжиргааг дэмжих жил” болгохоор аймгийн ИТХ-аас шийдвэрлэж жилийн ажлыг зохион байгуулах хороо байгуулагдан, ажлаа төлөвлөж хэрэгжилтийг зохион байгуулж байна.

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР